



МОНГОЛБАНКНЫ  
ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТУШААЛ

2019 оны 04 сарын 05 өдөр

Дугаар А-92

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5 дахь хэсэг, 8 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 28 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалт, Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.3 дахь хэсэг, 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсэг, 12 дугаар зүйлийн 12.3 дахь хэсэг, 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Төлбөрийн картын журам”-ыг хавсралт ёсоор баталсугай.
2. Батлагдсан журмыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг Төлбөр тооцооны газар (Э.Анар), төлбөрийн үйлчилгээ үзүүлэгч нарт тус тус үүрэг болгосугай.
3. Энэ тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төлбөр тооцооны газар (Э.Анар), Дотоод аудитын газар (Т.Амарсайхан)-т тус тус даалгасугай.
4. “Төлбөрийн картын журам”-ыг Хууль, зүй дотоод хэргийн яамны Улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэхийг Хууль, эрх зүйн газар (Д.Аюуш), Төлбөр тооцооны газар (Э.Анар)-т тус тус даалгасугай.
5. Журам бүртгэгдсэн өдрөөс эхлэн Монголбанкны Ерөнхийлөгчийн 2017 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн А-327 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛБАНКНЫ  
ЕРӨНХИЙЛӨГЧ



Н.БАЯРТСАЙХАН

14 0852

Tushaal 2019.doc



## ТӨЛБӨРИЙН КАРТЫН ЖУРАМ

### НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Энэхүү журмын зорилго нь Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5 дахь хэсэг, 8 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 20 дугаар зүйл, 28 дугаар зүйлийн 28.1.2 дахь заалт, Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.3 дахь хэсэг, 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсэг, 12 дугаар зүйлийн 12.3 дахь хэсэг, 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсгийн дагуу төлбөрийн карт (цаашид “карт” гэх)-ын Монгол Улсын нутаг дэвсгэр дэх үйл ажиллагааг зохицуулах, зөвшөөрөл олгох, хүчингүй болгох, оролцогчийн эрх, үүрэг, хариуцлагыг тодорхойлох, хэрэгжилтэд хяналт тавихад оршино.
- 1.2. Картын үйл ажиллагаанд Иргэний хууль, Төв банк (Монголбанк)-ны тухай хууль, Банк, эрх бүхий этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хууль, Үндэсний төлбөрийн системийн тухай хууль, энэхүү журам, Монголбанкнаас гаргасан холбогдох бусад эрх зүйн баримт бичгийг мөрдлөг болгоно.
- 1.3. Картын үйл ажиллагаанд оролцогч нь олон улсад зөвшөөрөгдсөн стандартыг дагаж мөрдөнө.
- 1.4. Картын үйл ажиллагаанд оролцогч нь Монгол Улсын нутаг дэвсгэр дээр картаар хийгдэх санхүүгийн гүйлгээг төгрөгөөр гүйцэтгэнэ.

### ХОЁР. НЭР ТОМЬЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ

- 2.1. Энэхүү журамд хэрэглэгдэх нэр томьёог дор дурдсан утгаар ойлгоно:
  - 2.1.1. “Автомат теллер машин” (цаашид “АТМ” гэх) гэж карт хүлээн авагчийн системд холбогдсон, картаар идэвхжиж гүйлгээ хийдэг цахим мэдээ үүсгэгчийг;
  - 2.1.2. “Биет карт” гэж ISO/IEC 7810 ID-1 стандартын бэлдэц дээр картын мэдээллийг хэвлэсэн төлбөрийн хэрэгслийг;
  - 2.1.3. “Биет бус карт” гэж цахим худалдаанд ашиглагдах, биетээр хэвлэгдээгүй картын мэдээлэл бүхий төлбөрийн хэрэгслийг;
  - 2.1.4. “Бодит цагийн горим” гэж картын гүйлгээг үүссэн даруй нь хүлээн авах буюу дамжуулахыг;
  - 2.1.5. “Гүйлгээ” гэж төлбөрийн карт ашиглаж, цахим мэдээ үүсгэгчийн тусламжтайгаар мөнгөн хөрөнгө шилжүүлэх, дансны үлдэгдэл шалгах, ПИН код өөрчлөх, гүйлгээний баримт авах зэрэг үйлдлийг. Гүйлгээ нь энэ журмын 2.1.25, 2.1.26-д заасан хэлбэртэй байна;
  - 2.1.6. “Гүйлгээний боловсруулалт” гэж картын гүйлгээ, үр дүнгийн тооцооллыг програм хангамжийн тусламжтайгаар гүйцэтгэхийг;
  - 2.1.7. “Гүйлгээ дамжуулах өдөр” гэж тухайн өдрийн 00 цагаас дараагийн өдрийн 00 цаг хүртэлх хугацааг;
  - 2.1.8. “Гүйлгээний зөвшөөрөл” гэж карт гаргагчаас тухайн гүйлгээг хүлээн зөвшөөрсөн цахим мэдээг;

- 2.1.9. “Гэнэтийн саатал” гэж картын системийн үйл ажиллагаа хоёр минутаас дээш хугацаагаар, төлөвлөгөөт бусаар хэсэгчлэн болон бүрэн зогсохыг;
- 2.1.10. “Зайнаас унших” гэж картын зайнаас мэдрэгч чипийг цахим мэдээ үүсгэгчид уншуулан картын гүйлгээ үүсгэхийг;
- 2.1.11. “Залилангийн гүйлгээ” гэж бусдын дансанд байгаа мөнгөн хөрөнгийг эзэмших, захиран зарцуулах эрхгүй этгээд итгэл эвдэх буюу хуурч мэхлэх аргаар, санаатайгаар өөрийн эзэмшилд оруулах буюу захиран зарцуулахыг;
- 2.1.12. “Залруулгын гүйлгээ” гэж картын үйл ажиллагаанд гарсан алдаа, маргааныг шийдвэрлэх зорилгоор карт хүлээн авагчийн үүсгэж буй гүйлгээг;
- 2.1.13. “Карт гаргагч” гэж Монголбанкнаас карт гаргах үйл ажиллагааны зөвшөөрөл авсан хуулийн этгээдийг;
- 2.1.14. “Карт гаргагчийг таних дугаар” (цаашид “БИН” гэх) гэж карт гаргагчийг бусдаас ялгах зорилгоор олон улсад зөвшөөрөгдсөн картын байгууллагаас болон Монголбанкнаас олгосон картын дугаарын эхний 6-8 оронг илэрхийлэх тоон дарааллыг;
- 2.1.15. “Картын системийн шууд оролцогч” гэж өөрийн болон шууд бус оролцогчийн картын гүйлгээний боловсруулалтыг хийж байгаа, ҮЦГТ-тэй шууд холбогдсон хуулийн этгээдийг;
- 2.1.16. “Картын системийн шууд бус оролцогч” гэж шууд оролцогчоор картын гүйлгээний боловсруулалтаа хийлгэдэг, ҮЦГТ-тэй шууд холбогдоогүй хуулийн этгээдийг;
- 2.1.17. “Карт хүлээн авагч” гэж Монголбанкнаас карт хүлээн авах үйл ажиллагааны зөвшөөрөл авсан хуулийн этгээдийг;
- 2.1.18. “Клирингийн төвийн шимтгэл” гэж карт гаргагч болон карт хүлээн авагчаас клирингийн төвийн шимтгэн тооцож буй дүнг;
- 2.1.19. “КҮБ” гэж бараа, ажил үйлчилгээний төлбөрийг карт болон цахим мэдээ үүсгэгчийн тусламжтайгаар банкин дахь харилцах дансандаа хүлээн авах хувь хүн, хуулийн этгээдийг;
- 2.1.20. “КҮБ-ын шимтгэл” гэж бараа, ажил үйлчилгээний төлбөрийг картын системээр дамжуулан хүлээн авах тохиолдолд КҮБ-аас карт хүлээн авагчийн шимтгэн тооцож буй мөнгөн дүнг;
- 2.1.21. “МПОС төхөөрөмж” гэж ухаалаг гар утасны тусламжтайгаар, картаар идэвхжиж, гүйлгээ хийдэг цахим мэдээ үүсгэгчийг;
- 2.1.22. “ПОБ төхөөрөмж” гэж карт хүлээн авагч өөрийн салбар, нэгжид байршуулж, системдээ холбосон, картаар идэвхжиж, гүйлгээ хийдэг цахим мэдээ үүсгэгчийг;
- 2.1.23. “ПОС төхөөрөмж” гэж карт хүлээн авагчийн системд холбогдсон, төлбөр хийх зориулалтаар КҮБ-д байршуулсан, картаар идэвхжиж, гүйлгээ хийдэг цахим мэдээ үүсгэгчийг;
- 2.1.24. “Процессор” гэж Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн 5.1.17-д заасан дэмжлэгийг карт гаргагч, карт хүлээн авагчид үзүүлэх хуулийн этгээдийг;
- 2.1.25. “Санхүүгийн гүйлгээ” гэж Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн 5.1.18-д заасан үйл ажиллагааг цахим мэдээ үүсгэгч ашиглан гүйцэтгэхийг;
- 2.1.26. “Санхүүгийн бус гүйлгээ” гэж энэ журмын 2.1.25-д зааснаас бусад үйл ажиллагааг цахим мэдээ үүсгэгч ашиглан гүйцэтгэхийг;

- 2.1.27. “Соронзон тууз унших арга” гэж картын соронзон туузыг цахим мэдээ үүсгэгчид уншуулан картын гүйлгээ үүсгэхийг;
  - 2.1.28. “Сүлжээний дүрэм” гэж клирингийн төвийн ажиллуулж буй картын системд холбогдох мөрдөх техникийн стандарт болон холбогдох гэрээг;
  - 2.1.29. “Төлбөрийн карт” (цаашид “карт” гэх) гэж Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн 5.1.24-т заасныг;
  - 2.1.30. “Төлбөрийн картын систем” гэж төлбөрийн карт, төлбөрийн картын системийн үйл ажиллагаа, түүний оролцогч, тэдгээрийн ашиглаж буй програм хангамж, техник тоног төхөөрөмж, холбогдох бодлого, журам, заавар, гэрээ бүхий цогц нэгдлийг;
  - 2.1.31. “Төлбөрийн картын системийн оролцогч” (цаашид “оролцогч” гэх) гэж карт гаргагч, карт хүлээн авагч, ҮЦГТ, клирингийн төв болон процессорыг;
  - 2.1.32. “Төлөвлөгөөт зогсолт” гэж оролцогч нь засвар, үйлчилгээ хийх зорилгоор бусад оролцогчид урьдчилан мэдэгдсний дагуу картын системийн үйл ажиллагааг хэсэгчлэн болон бүрэн зогсоохыг;
  - 2.1.33. “Төрийн үйлчилгээний төлбөр” гэж төрийн байгууллагаас үзүүлж буй үйлчилгээний төлбөр, татвар, торгууль, хураамж зэргийг картаар төлж, Төрийн сангийн дансанд нэг бүрчлэн тусгахыг;
  - 2.1.34. “Үндэсний төлбөрийн карт” (цаашид “₮ карт” гэх) гэж Монголбанкнаас тодорхойлсон стандартыг хангасан, ₮ картын лого бүхий, дотоодод болон олон улсад төлбөрт ашиглагдах картыг;
  - 2.1.35. “ҮЦГТ” гэж Монголбанкны Үндэсний цахим гүйлгээний төвийг;
  - 2.1.36. “Хосолсон ₮ карт” гэж карт гаргагчаас олон улсад зөвшөөрөгдсөн картын үйл ажиллагаа эрхлэгч байгууллагатай хамтран гаргасан, тухайн байгууллагын карт хүлээн авах сүлжээнд ашиглах боломжтой ₮ картыг;
  - 2.1.37. “Хувийн нууц дугаар” (цаашид “ПИН код” гэх) гэж картын гүйлгээг баталгаажуулахад ашиглагдах, зөвхөн тухайн карт эзэмшигч мэдэж байх тоон дарааллыг;
  - 2.1.38. “Хулгайн гүйлгээ” гэж бусдын дансанд байгаа мөнгөн хөрөнгийг эзэмших, захиран зарцуулах эрхгүй этгээд санаатайгаар, нууцаар өөрийн эзэмшилд оруулах буюу захиран зарцуулахыг;
  - 2.1.39. “Цахим мэдээ” гэж картын гүйлгээний цахим хэлбэрийг;
  - 2.1.40. “Цахим мэдээ үүсгэгч” гэж карт, картын мэдээлэл ашиглан картын гүйлгээ үүсгэж буй төхөөрөмж, програм хангамжийг;
  - 2.1.41. “Цахим худалдаа” гэж интернэтийн тусламжтайгаар карт ашиглан бараа, ажил үйлчилгээний төлбөр төлөхийг;
  - 2.1.42. “Чип унших арга” гэж картын чипийг цахим мэдээ үүсгэгчид уншуулан картын гүйлгээ үүсгэхийг;
  - 2.1.43. “Эзэмшигчийн нэр бичигдээгүй карт” гэж картын нүүрэн талд карт эзэмшигчийн нэр бичигдээгүй картыг.
- 2.2. Энэхүү журмын 2.1-д тодорхойлсон болон энэ журамд хэрэглэсэн бусад нэр томъёог уг журмын 1 дүгээр хавсралтад заасны дагуу англи хэл дээр орчуулж хэрэглэнэ.

## ГУРАВ. КАРТ, КАРТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА, ОРОЛЦОГЧ

- 3.1. Карт нь хандаж байгаа данснаас хамаарч дараахь төрөлтэй байж болно:
  - 3.1.1. Банкинд байрших харилцах, хадгаламжийн данс руу хандах боломжтой дебит карт;
  - 3.1.2. Банк, ББСБ дээр байрших дансанд гэрээний дагуу зээл үүсгэх боломжтой кредит карт;
  - 3.1.3. Мөнгөн хөрөнгө урьдчилан байршуулсан банкин дахь данс руу хандаж тухайн карт гаргагчийн сүлжээнд, зөвхөн нэг хуулийн этгээдэд худалдан авалт хийх боломжтой урьдчилсан төлбөрт карт.
- 3.2. Карт нь цахим мэдээ үүсгэгч дээр уншигдах аргаас хамаарч дараахь төрөлтэй байж болно:
  - 3.2.1. Соронзон туузтай;
  - 3.2.2. Чиптэй;
  - 3.2.3. Зайн мэдрэгчтэй.
- 3.3. Картыг дараахь байдлаар хэрэглэж болно:
  - 3.3.1. Картыг биет байдлаар уншуулах;
  - 3.3.2. Картын мэдээллийг ашиглах.
- 3.4. Карт нь дор дурдсан мэдээллийг агуулна:
  - 3.4.1 Карт гаргагч, хамтран гаргагчийн нэр, картын таних тэмдэг /лого/, эсхүл олон улсын картын байгууллагын таних тэмдэг /лого/;
  - 3.4.2 ₮ карт дээр ҮЦГТ-ийн лого;
  - 3.4.3 Карт эзэмшигчийн нэр/байгууллагын нэр (эзэмшигчийн нэр бичигдээгүй картаас бусад картад хамаарна);
  - 3.4.4 Монголбанкнаас эсхүл олон улсын картын байгууллагаас олгосон БИН-г агуулсан картын дугаар;
  - 3.4.5 Картын хүчинтэй хугацаа;
  - 3.4.6 Карт гаргагчийн хаяг, холбоо барих утас, факсын дугаар, цахим шуудангийн хаяг;
  - 3.4.7 Карт эзэмшигчийн гарын үсэг байрлах хэсэг;
  - 3.4.8 Бусад.
- 3.5. Карт ашиглан дараахь үндсэн ба нэмэлт гүйлгээг хийнэ:
  - 3.5.1. Үндсэн гүйлгээ:
    - а) АТМ, ПОБ төхөөрөмжийн тусламжтайгаар бэлэн мөнгөний зарлагын гүйлгээ хийх;
    - б) АТМ, ПОБ төхөөрөмжийн тусламжтайгаар дансны үлдэгдэл шалгах;
    - в) АТМ төхөөрөмжийн тусламжтайгаар гүйлгээний хуулга авах;
    - г) ПОС төхөөрөмжийн тусламжтайгаар төлбөрийн гүйлгээ хийх, буцаалтын гүйлгээ хийх;
    - д) Цахим худалдааны гүйлгээ хийх;
    - е) Төрийн үйлчилгээний төлбөр хийх<sup>1</sup>.
  - 3.5.2. Нэмэлт гүйлгээ:

---

<sup>1</sup> Өөрийн гаргасан картаар төрийн үйлчилгээний төлбөр төлөх

- а) АТМ төхөөрөмжийн тусламжтайгаар бэлэн мөнгөний орлогын гүйлгээ хийх;
  - б) АТМ төхөөрөмжийн тусламжтайгаар шилжүүлэг хийх;
  - в) АТМ, ПОБ төхөөрөмжийн тусламжтайгаар төлбөр төлөх;
  - г) АТМ, ПОБ төхөөрөмжийн тусламжтайгаар ПИН код солих;
  - д) АТМ, ПОБ төхөөрөмжийн тусламжтайгаар буцаалт болон хэсэгчилсэн буцаалтын гүйлгээг хийх;
  - е) ПОБ төхөөрөмжийн тусламжтайгаар бэлэн мөнгөний орлогын гүйлгээ хийх;
  - ё) ПОС төхөөрөмжийн тусламжтайгаар бэлэн мөнгөний зарлагын гүйлгээ хийх (cashback);
  - ж) ПОС төхөөрөмжийн тусламжтайгаар төрийн үйлчилгээний төлбөр хүлээн авах<sup>2</sup>;
  - з) ПОС төхөөрөмжийн тусламжтайгаар гүйлгээний урьдчилсан зөвшөөрөл авах;
  - и) Олон улсын стандарт болон ҮЦГТ-ийн сүлжээний дүрэмд нийцсэн бусад гүйлгээ.
- 3.6. Дараахь гүйлгээнд баталгаажуулалт шаардахгүй байж болно:
- 3.6.1. 10,000 (арван мянган) төгрөг хүртэлх дүнтэй гүйлгээ.
- 3.7. Дараахь гүйлгээнд баталгаажуулалт шаардана:
- 3.7.1. 10,000 (арван мянган) төгрөгөөс дээш дүнтэй гүйлгээг ПИН кодоор;
  - 3.7.2. Цахим худалдааны гүйлгээг ПИН код эсвэл CVV кодоор;
  - 3.7.3. МПОС төхөөрөмжийн гүйлгээг гарын үсгээр.
- 3.8. Картын үйл ажиллагаанд дараахь талууд оролцоно:
- 3.8.1. ҮЦГТ;
  - 3.8.2. Карт гаргагч;
  - 3.8.3. Карт хүлээн авагч;
  - 3.8.4. Карт эзэмшигч;
  - 3.8.5. КУБ;
  - 3.8.6. Клирингийн төв;
  - 3.8.7. Процессор.

### **ДӨРӨВ. КАРТ ГАРГАГЧИД ТАВИХ ШААРДЛАГА**

- 4.1. Карт гаргагч нь Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн 12.1-д заасан болон дараахь шаардлагыг хангана:
- 4.1.1. Карт гаргагч нь Компанийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжид заасны дагуу үүсгэн байгуулагдсан хуулийн этгээд байх;
  - 4.1.2. Карт гаргагчийн хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээ нь 2,500,000,000 (хоёр тэрбум таван зуун сая) төгрөг байна. Энэхүү хувь нийлүүлсэн хөрөнгийг зээлийн эх үүсвэрээр бүрдүүлээгүй байх;
  - 4.1.3. Карт гаргагч нь банк бол үр дүнгийн төлбөр тооцоо хийх зориулалт бүхий дансыг Монголбанкинд нээсэн байх, банкнаас бусад этгээд бол төлбөр тооцооны төлөөлөгчид нээх;

---

<sup>2</sup> Төрийн үйлчилгээний төлбөрийг хүлээн авах

- 4.1.4. Төлбөрийн карт гаргах үйл ажиллагааны зөвшөөрлийг энэхүү журам болон холбогдох хууль тогтоомжийн дагуу Монголбанкнаас авах;
- 4.1.5. Төлбөрийн системд мөрдөх мэдээллийн технологийн тасралтгүй, найдвартай ажиллагааны журмын шаардлагыг хангах;
- 4.1.6. Картын үйлчилгээ үзүүлэх тусгай нэгж, газар хэлтэстэй байх.
- 4.2. Банкны үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл бүхий этгээдэд энэ журмын 4.1.2 дахь заалт хамаарахгүй.
- 4.3. Карт гаргагч дараахь үүрэгтэй:
  - 4.3.1. Карт гаргагчийн нийтлэг үүрэг:
    - а) Урьдчилсан төлбөрт картаас бусад карт нь энэ журмын 3.5.1-д заасан үндсэн гүйлгээг карт хүлээн авагч бүх хуулийн этгээдийн сүлжээнд хийх боломжтой байх;
    - б) Карт гаргах үйл ажиллагааны зөвшөөрлийг Монголбанкнаас авсан өдрөөс эхлэн 6 сарын дотор тухайн картын гүйлгээг ҮЦГТ-ийн сүлжээгээр дамжуулах боломжыг хангах;
    - в) Карт эзэмшигчийн хувийн нууцад хамаарах болон гүйлгээний мэдээллийг түүний зөвшөөрөлгүйгээр гуравдагч этгээдэд дамжуулахгүй, хууль тогтоомж болон энэ журамд зааснаас бусад зориулалтаар ашиглахгүй байх;
    - г) Картын гүйлгээний хуулганд тухайн гүйлгээ хийгдсэн КУБ-ын нэр, байршлыг ойлгомжтой байдлаар оруулах;
    - е) Цахим худалдааны гүйлгээг ПИН код эсвэл CVV кодоор баталгаажуулахад гүйлгээнээс гарах эрсдлийг карт гаргагч хариуцна.
  - 4.3.2. Карт гаргагч нь карт эзэмшигчийн өмнө дараахь үүрэг хүлээнэ:
    - а) Карт эзэмшигчтэй гэрээ байгуулах;
    - б) Гүйлгээний зөвшөөрөл олгох болон гүйлгээний боловсруулалт хийх үйлчилгээг тасралтгүй үзүүлэх;
    - в) ПИН кодыг карт эзэмшигчийн зөвшөөрөлгүйгээр бусад мэдээлэхгүй байх;
    - г) Шуудан, интернэт, гар утас болон холбооны бусад хэрэгслээр дамжуулан шинээр олгож байгаа картын ПИН кодыг карт эзэмшигчид битүүмжилсэн байдлаар тусад нь хүлээлгэн өгөх;
    - д) ₮ картыг шинээр олгохдоо дотоодын цахим худалдааны эрхийг нээсэн байх;
    - е) Карт эзэмшигч картыг хүлээж авсан буюу хүлээн авснаа мэдэгдсэнээс хойш идэвхжүүлж байх;
    - ё) Карт, ПИН код алдагдсан нь эзэмшигчийн буруутай үйл ажиллагаанаас шалтгаалсан эсэхээс үл хамааран энэ журмын 4.5.9-ийн а, б, в-д заасан мэдэгдлийг карт эзэмшигчээс хүлээн авсан даруй гүйлгээний эрхийг хааж, цаашдын алдагдлаас сэргийлэх;
    - ж) Карт гаргагч нь карт эзэмшигчийн данснаас эрх олгогдоогүй шилжүүлэг хийгдсэн, хийгдэж болзошгүйг мэдсэн үеэс эхлэн энэ журмын 4.3.2-ийн ё-д заасан үүргийг хүлээх;
    - з) Карт эзэмшигчид гүйлгээний мэдээллийг үнэ төлбөргүй мэдэгдэх сувагтай байх.
  - 4.3.3. Карт гаргагч нь карт хүлээн авагчийн өмнө дараахь үүрэг хүлээнэ:
    - а) Сэжигтэй картын талаарх мэдээллээр хангах;

- б) Карт гаргагч нь карт эзэмшигчээс энэ журмын 4.5.9-ийн а, б, в-д заасан мэдэгдлийг хүлээн авснаас хойш хуурамч болон залилан мэхлэх шинжтэй гүйлгээ хийх зөвшөөрөл өгснөөс үүсэх хохирлыг хариуцах;
- в) Карт хүлээн авагчийн үүсгэсэн маргааныг хамтран ажиллах гэрээнд заасны дагуу шийдвэрлэх;
- г) Карт хүлээн авагчийн гүйлгээнд гэрээнд заасан хугацааны дагуу хариу өгөх.

4.3.4. Карт гаргагч нь клирингийн төвийн өмнө дараахь үүрэг хүлээнэ:

- а) Хамтран ажиллах гэрээ байгуулах, түүнийг даган мөрдөх;
- б) Клирингийн төвийн шимтгэл хуваах зарчмыг даган мөрдөх;
- в) Клирингийн төвөөр дамжсан картын гүйлгээний маргааныг гэрээнд заасан хугацаанд багтаан шийдвэрлэх;
- г) Картын БИН-г гэрээнд заасан хугацаанд бүртгүүлэх;
- д) Картын гүйлгээнд гэрээнд заасан хугацааны дагуу хариу өгөх;
- е) Клирингийн төвөөс тавих техник технологийн шаардлагыг хангаж ажиллах, техник технологийн өөрчлөлт орсон тохиолдолд туршилт хийж дүгнэлт гаргуулах.

4.4. Карт гаргагч нь энэ журмын 3.1, 3.2-т заасан картыг гаргах эрхтэй.

4.5. Карт гаргагч нь карт эзэмшигчтэй байгуулах гэрээнд дараахь нөхцөлийг заавал тусгана:

- 4.5.1. Тухайн төлбөрийн картын тодорхойлолт, ашиглаж болох төхөөрөмж, хэрэгсэл, ашиглах арга, гүйцэтгэх үйлдлийн төрөл, гүйлгээний үнийн дүнгийн болон давтамжийн хязгаарлалт байгаа бол тус нөхцөлийг;
- 4.5.2. Карт гаргагч болон эзэмшигчийн эрх үүрэг, хариуцлага;
- 4.5.3. Картыг ашиглахтай холбогдсон үйлчилгээний хураамж, хүү, шимтгэл авах бол тус нөхцөлийг:
  - а) Элсэлтийн болон жилийн хураамжийн хэмжээ;
  - б) Гүйлгээний шимтгэлийн төрөл, хэмжээ;
  - в) Хүүний хэмжээ болон хүү тооцох аргачлал.
- 4.5.4. Энэ журмын 4.5.3-т заасан үйлчилгээний хураамж, хүү, шимтгэлийг карт эзэмшигчийн данснаас суутгах нөхцөл, хугацааны талаарх мэдээлэл;
- 4.5.5. Гомдол, маргаан үүсгэх эрх, хугацааны хязгаар, гаргах хэлбэр;
- 4.5.6. Карт эзэмшигчийн мэдэгдлийн дагуу авах арга хэмжээ, шийдвэрлэх болон хариу өгөх хугацаа;
- 4.5.7. Карт нь гадаадад ашиглах эрхтэй бол гүйлгээний шимтгэл, хураамж, хөрвүүлэх ханш, дансанд тусгах хугацаа;
- 4.5.8. Карт гаргагч нь гэрээнд өөрчлөлт оруулах талаар карт эзэмшигчид хуанлийн 30 (гуч) хоногийн өмнө мэдэгдсэнээр гэрээний нөхцөлд өөрчлөлт оруулах эрхтэй. Заасан хугацаанд карт эзэмшигч гэрээнээс татгалзаагүй бол, гэрээний өөрчлөлтийг хүлээн зөвшөөрсөнд тооцох тухай;
- 4.5.9. Гэрээнд карт эзэмшигчийн хүлээх дараахь үүргийг заавал тусгана:
  - а) Карт буюу ПИН кодыг хаяж үрэгдүүлсэн, хулгайд алдсан тохиолдолд карт гаргагчид нэн даруй мэдэгдэх;



- б) Өөрийн данснаас эрх олгогдоогүй шилжүүлэг хийгдсэн болон бүртгэлийн аливаа алдаа, зөрчил дутагдлыг илрүүлсэн тохиолдолд карт гаргагчид нэн даруй мэдэгдэх;
  - в) Өөрийн ПИН кодыг гуравдагч этгээд мэдсэн байж болзошгүй гэж үзсэн тохиолдолд карт гаргагчид нэн даруй мэдэгдэх;
  - г) Картыг бусдад ашиглуулахгүй байх;
  - д) ПИН кодыг нууцлах.
- 4.6. Карт эзэмшигч энэ журмын 4.5.9-ийн а, б, в-д заасан мэдэгдлийг өөрийн биеэр, бичгээр, утсаар өгч болно.
- 4.7. Карт гаргагч нь Монголбанкинд холбогдох мэдээллийг ирүүлэн дүгнэлт гаргуулсны үндсэн дээр аливаа хуулийн этгээдтэй хамтран, харилцан ашигтай байдлаар ко-бренд карт гаргаж болно.
- 4.8. Карт гаргагч нь Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн зохицуулалтыг хангаж ажиллана.

#### **ТАВ. КАРТ ХҮЛЭЭН АВАГЧИД ТАВИХ ШААРДЛАГА**

- 5.1. Карт хүлээн авагч нь Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн 12.1-д заасан болон дараахь шаардлагыг хангана:
- 5.1.1. Карт хүлээн авагч Компанийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид заасны дагуу үүсгэн байгуулагдсан хуулийн этгээд байх;
  - 5.1.2. Карт хүлээн авагчийн хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээ нь 2,500,000,000 (хоёр тэрбум таван зуун сая) төгрөг байна. Энэхүү хувь нийлүүлсэн хөрөнгийг зээлийн эх үүсвэрээр бүрдүүлээгүй байх;
  - 5.1.3. Карт хүлээн авагч нь банк бол үр дүнгийн тооцоо хийх зориулалт бүхий дансыг Монголбанкинд, банкнаас бусад этгээд бол төлбөр тооцооны төлөөлөгчид нээх;
  - 5.1.4. Төлбөрийн карт хүлээн авах үйл ажиллагааны зөвшөөрлийг энэхүү журам болон холбогдох хууль тогтоомжийн дагуу Монголбанкнаас авах;
  - 5.1.5. Төлбөрийн системд мөрдөх мэдэллийн технологийн тасралтгүй, найдвартай ажиллагааны журмын шаардлагыг хангах;
  - 5.1.6. Картын үйлчилгээ үзүүлэх тусгай нэгж, газар хэлтэстэй байх.
- 5.2. Банкны үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл бүхий этгээд энэ журмын 5.1.2 дахь заалт хамаарахгүй.
- 5.3. Карт хүлээн авагч дараахь үүрэгтэй:
- 5.3.1. Карт хүлээн авагчийн нийтлэг үүрэг:
    - а) Монголбанкнаас олгосон зөвшөөрөлд заасан картыг хүлээн авах ба энэ журмын 3.5.1-д заасан үндсэн гүйлгээг хийх боломжийг өөрийн болон бусад карт гаргагчийн карт эзэмшигчид олгох;
    - б) Карт гаргагч, карт хүлээн авагч хоорондын төлбөрийн картын дотоодын гүйлгээг ҮЦГТ болон клирингийн төвөөр дамжуулан гүйцэтгэх;
    - в) ПОС төхөөрөмж нь олон улсын чип EMV (EMV contact Level 1, Level 2 type approval) стандартын сертификаттай байх;

- г) Зайн мэдрэгч унших боломжтой ПОС төхөөрөмж нь олон улсын зайн EMV (EMV contactless Level 1, Level 2 type approval) стандартын сертификаттай байх;
- д) Карт эзэмшигчийн хувийн нууцад хамаарах болон гүйлгээний мэдээллийг түүний зөвшөөрөлгүйгээр гуравдагч этгээдэд дамжуулахгүй, хууль тогтоомж болон энэ журамд зааснаас бусад зориулалтаар ашиглахгүй;
- е) Баталгаажуулалт хийгдээгүй гүйлгээнээс гарах эрсдэлийг хариуцах;
- ё) Энэ журмын 3.5.2-ын ё-д заасан ПОС төхөөрөмжийн тусламжтайгаар бэлэн мөнгө авах гүйлгээг зөвхөн худалдан авалттай цуг хийх ба тухайн худалдан авалтын үнийн дүнгээс хэтрүүлэхгүй;
- ж) КҮБ-ын нэр болон байршлыг тухайн гүйлгээний цахим мэдээ дотор үнэн зөв бичиж явуулах;

5.3.2. Карт хүлээн авагч нь карт гаргагчийн өмнө дараахь үүрэг хүлээнэ:

- а) Карт гаргагчийн үүсгэсэн маргааныг хамтран ажиллах гэрээнд заасны дагуу шийдвэрлэх;
- б) КҮБ-ын шимтгэлийг ҮЦГТ болон клирингийн төвтэй байгуулсан гэрээнд заасан хуваах зарчмын дагуу төлөх.

5.3.3. Карт хүлээн авагч нь зөвхөн худалдаа, үйлчилгээ эрхэлдэг хувь хүн, хуулийн этгээдийг КҮБ-аар элсүүлэн, гэрээ байгуулна.

5.3.4. Карт хүлээн авагч нь КҮБ-ын өмнө дараахь үүрэг хүлээнэ:

- а) Үйлчилгээний нөхцөлийг тодорхой заасан гэрээ байгуулах;
- б) КҮБ-ыг ПОС төхөөрөмж дээр ажиллаж сургах;
- в) Хуурамч болон залилан мэхлэх шинжтэй гүйлгээ илрүүлсэн тохиолдолд шуурхай арга хэмжээ авах;
- г) КҮБ-ын үүсгэсэн маргааныг дор бүр нь судалж, гэрээнд заасан хугацаанд шийдвэрлэх;
- д) ПОС төхөөрөмжийн тасралтгүй, найдвартай ажиллагааг хангах;
- е) Хуурамч болон залилангийн гүйлгээнээс урьдчилан сэргийлэх зорилгоор заавар зөвлөмжөөр хангах.

5.3.5. Карт хүлээн авагч нь КҮБ-тай байгуулах гэрээнд дараахь нөхцөлийг тусгана:

- а) Картыг бэлэн мөнгөний нэгэн адил тооцож ижил үнээр төлбөрт хүлээн авах;
- б) Төрийн үйлчилгээний төлбөр төлөх гүйлгээнээс бусад тохиолдолд карт эзэмшигчээс картаар үйлчилсний шимтгэл авахгүй байх;
- в) Картыг эзэмшигчийн дэргэд ПОС төхөөрөмж дээр уншуулах;
- г) Карт эзэмшигч ПИН кодыг зөвхөн өөрөө оруулах боломжоор хангах;
- д) Картын гүйлгээний үр дүнг банкин дахь харилцах дансаар хүлээн авах;
- е) ПОС төхөөрөмжийг Монгол Улсын нутаг дэвсгэрт зөвхөн гэрээнд заасан байршилд буюу урьдчилан тодорхойлсон нутаг дэвсгэрийн хүрээнд байршуулах;
- ё) ПОС төхөөрөмжийн эзэмшигч болон ашиглах байршил өөрчлөгдөх тухай бүр гэрээг шинэчлэн байгуулах;
- ж) КҮБ-ын үүсгэсэн маргааныг шийдвэрлэж, хариу өгөх хугацаа;

- з) КҮБ-д тавигдах шаардлагыг хангуулж, хяналт тавих;
  - и) КҮБ-ын гүйлгээг залилан буюу луйврын шинж чанартай гэж сэжиглэсэн тохиолдолд тухайн гүйлгээг КҮБ-тай хийх тооцоонд оруулалгүй, маргаан шийдэгдэх хүртэл дансанд хөдөлгөөнгүйгээр барих.
- 5.3.6. Карт хүлээн авагч нь клирингийн төвийн өмнө дараахь үүрэг хүлээнэ:
- а) Хамтран ажиллах гэрээ байгуулах, түүнийг даган мөрдөх;
  - б) Клирингийн төвийн тогтоосон КҮБ-ын шимтгэл хуваах зарчмыг мөрдөх;
  - в) Клирингийн төвөөр дамжсан картын гүйлгээний маргааныг гэрээнд заасан хугацаанд багтаан шийдвэрлэх;
  - г) Картын БИН-г гэрээнд заасан хугацаанд бүртгэх;
  - е) Клирингийн төвөөс тавих техник технологийн шаардлагыг хангаж ажиллах, техник технологийн өөрчлөлт орсон тохиолдолд туршилт хийж, дүгнэлт гаргуулах;
  - ё) Шинээр суурилуулж байгаа болон өөрчлөлт хийж байгаа цахим мэдээ үүсгэгчид ҮЦГТ-өөс ашиглалтын дүгнэлт авах (цахим мэдээ үүсгэгчийн загварыг тестэлнэ);
  - ж) Цахим мэдээ үүсгэгч дээр ҮЦГТ-ийн логог карт эзэмшигчид харагдахуйцаар байршуулах;
  - з) Энэ журмын 3 дугаар хавсралтад заасан цахим мэдээ үүсгэгчид тавигдах шаардлагыг хангаж ажиллах.

5.4. Карт хүлээн авагч нь КҮБ дээр тавигдсан ПОС төхөөрөмжийн тохиргоонд тухайн КҮБ-ын үйл ажиллагааны ангилал код (Merchant category code)-ыг 2 дугаар хавсралтад заасны дагуу бүртгэж, үнэн зөв оруулна.

5.4.1. Зөвхөн төрийн үйлчилгээ үзүүлэх зорилгоор байршуулсан ПОС төхөөрөмжид КҮБ-ын үйл ажиллагааны ангилал 9222, 9311, 9399 кодыг оруулна.

### **ЗУРГАА. ПРОЦЕССОРТ ТАВИХ ШААРДЛАГА**

- 6.1. Процессор нь карт гаргагч, хүлээн авагчтай хамтран ажиллах гэрээ байгуулсны үндсэн дээр түүний карт гаргах, хүлээн авах үйл ажиллагаанд Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн 5.1.17-д заасан техник технологи, мэргэжлийн боловсон хүчний болон Монголбанкнаас тодорхойлох бусад дэмжлэгийг үзүүлнэ.
- 6.2. Процессор нь дараахь шаардлагыг хангасан байна:
- 6.2.1. Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн 10.1.2-т заасан төлбөрийн үйлчилгээ үзүүлэхтэй хамаарал бүхий үйл ажиллагааны зөвшөөрлийг Монголбанкнаас авах;
  - 6.2.2. Энэ журмын 6.1-д заасан дэмжлэг үзүүлэх чадвартай мэргэжлийн боловсон хүчинтэй байх;
  - 6.2.3. Энэ журмыг мөрдөн ажиллахыг хүлээн зөвшөөрөх;
  - 6.2.4. Энэ журмын 6.1-д заасан дэмжлэгийг тасралтгүй, найдвартай үзүүлэх дэд бүтэц, програм хангамжтай байх;
  - 6.2.5. Карт гаргагч, хүлээн авагч хоорондын гүйлгээг ҮЦГТ болон клирингийн төвөөр дамжуулж гүйцэтгэх.
- 6.3. Процессор нь дараахь үүрэгтэй:

- 6.3.1. Карт гаргагч, хүлээн авагчтай хамтран ажиллах гэрээ байгуулах;
  - 6.3.2. Энэ журмын 6.1-д заасан дэмжлэгийг тасралтгүй үзүүлэх;
  - 6.3.3. Мэдээллийн нууцлал аюулгүй байдлыг бүрэн хангах;
  - 6.3.4. Карт эзэмшигчийн хувийн нууцад хамаарах болон гүйлгээний мэдээллийг карт эзэмшигчийн зөвшөөрөлгүйгээр гуравдагч этгээдэд дамжуулахгүй, хууль тогтоомж болон энэ журамд зааснаас бусад зориулалтаар ашиглахгүй байх.
- 6.4. Процессор нь карт гаргагч, хүлээн авагчтай байгуулсан гэрээнд дараахь нөхцөлийг тусгана:
- 6.4.1. Талуудын эрх, үүрэг, хүлээх хариуцлага;
  - 6.4.2. Үйлчилгээний шимтгэл, түүнийг хуваарилах зарчим;
  - 6.4.3. Төлбөрийг бодит цагийн горимоор дамжуулах тухай;
  - 6.4.4. Гомдол, маргаан шийдвэрлэх зарчим;
  - 6.4.5. Үйлчилгээний нууцлал, аюулгүй байдлыг бүрэн хангах тухай;
  - 6.4.6. Үйлчилгээний тасралтгүй, найдвартай байдлыг бүрэн хангах тухай.

### **ДОЛОО. ҮЦГТ-ИЙН ЭРХ, ҮҮРЭГ**

- 7.1. ҮЦГТ-ийн сүлжээний дүрмийг Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар батална.
- 7.2. ҮЦГТ нь өөрийн сүлжээн дэх гишүүдэд ижил хэмжээтэй шимтгэл болон нөхцөл бүхий сүлжээний дүрмийг тогтооно.
- 7.3. ҮЦГТ нь Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын нэрийн өмнөөс түүнтэй байгуулсан гэрээний үндсэн дээр карт хүлээн авах үйл ажиллагааг үнэ, төлбөртэйгөөр гүйцэтгэж болно.
- 7.4. ҮЦГТ нь тус төвийн сүлжээний оролцогчоор (цаашид гишүүн гэх) картын үйл ажиллагаатай холбоотой нэгдсэн стандартыг мөрдүүлж, системийн нэгдмэл байдлыг хангана.
- 7.5. ҮЦГТ нь мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг бүрэн хангана.
- 7.6. ҮЦГТ нь дараахь эрхтэйгээр клирингийн үйл ажиллагаа эрхэлнэ:
  - 7.6.1. Карт гаргагчтай байгуулсан гэрээний үндсэн дээр түүний өмнөөс гүйлгээний зөвшөөрлийг олгох;
  - 7.6.2. ҮЦГТ-ийн шимтгэлийг карт гаргагч болон карт хүлээн авагчаас авах.
- 7.7. ҮЦГТ нь дараахь үүрэгтэйгээр клирингийн үйл ажиллагаа эрхэлнэ:
  - 7.7.1. Карт гаргагч, хүлээн авагчтай хамтран ажиллах гэрээ байгуулах;
  - 7.7.2. Гишүүний картын гүйлгээний боловсруулалт, дамжуулалтыг тасралтгүй гүйцэтгэх;
  - 7.7.3. Картын гүйлгээний нууцлалыг хангах;
  - 7.7.4. Картаар хийгдсэн хулгай, залилангийн гүйлгээний мэдээллийн санг хөтлөн ажиллуулж, гишүүний зөвшөөрлөөр тус сангаас хууль хэрэгжүүлэх байгууллагад холбогдох мэдээллийг өгөх;
  - 7.7.5. Залруулгын гүйлгээ хийх, картын гүйлгээний маргааныг шийдвэрлэх боломжоор хангах, хяналт тавих;

- 7.7.6. Карт хүлээн авагчийн гүйлгээнд хамтран ажиллах гэрээнд заасан хугацааны дагуу хариу өгөх;
- 7.7.7. Картын гүйлгээний болон тасралтгүй ажиллагааны тайланг долоо хоног тутам гаргах, гишүүдийг тайлан, мэдээгээр хангах.
- 7.8. ҮЦГТ нь хамтран ажиллах гэрээ байгуулсны үндсэн дээр карт гаргагч, хүлээн авагчид техник, програм хангамжийн үйлчилгээ үзүүлж болно.
- 7.9. ҮЦГТ-ийн сүлжээний дүрэм эсхүл хамтран ажиллах гэрээнд дараахь нөхцөлийг тусгасан байна:
  - 7.9.1. Гишүүний эрх, үүрэг, хүлээх хариуцлага;
  - 7.9.2. Гишүүнээр элсэхэд тавигдах шаардлага;
  - 7.9.3. ҮЦГТ-ийн системд холбогдох мөрдөх техник, цахим мэдээний стандарт;
  - 7.9.4. Үйлчилгээний жагсаалт, тэдгээрийн дэлгэрэнгүй тайлбар;
  - 7.9.5. Шимтгэлийн хэмжээ, хуваарилах зарчим;
  - 7.9.6. Төлбөр, үр дүнгийн тооцоолол хийх зарчим, хуваарь;
  - 7.9.7. Маргаан шийдвэрлэх зарчим;
  - 7.9.8. Тасралтгүй ажиллагаа, аюулгүй байдлыг хангах аргачлал, тэдгээрийг хангаагүй тохиолдолд авах арга хэмжээ;
  - 7.9.9. Гишүүнтэй байгуулах гэрээний загвар.
- 7.10. ҮЦГТ нь сүлжээний дүрэм, хамтран ажиллах гэрээнд оруулсан өөрчлөлтийг хүчин төгөлдөр болохоос ажлын 15-аас доошгүй өдрийн өмнө гишүүдэд хүргүүлнэ.
- 7.11. ҮЦГТ-ийн сүлжээний дүрэм, хамтран ажиллах гэрээ нь олон нийтэд нээлттэй, ил тод байна.
- 7.12. Төлбөрийн картын гүйлгээний маргаан шийдвэрлэх зарчим болон хугацааг сүлжээний дүрэм, хамтран ажиллах гэрээнд тодорхой тусгана.

#### **НАЙМ. КАРТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ, ОЛГОХООС ТАТГАЛЗАХ, ХҮЧИНГҮЙ БОЛГОХ**

- 8.1. Карт гаргах үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авах хүсэлт гаргагч нь Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн 11.1-д болон дор дурдсан баримт бичгийн эх хувийг эсхүл баталгаажуулсан хувийг бүрдүүлж Монголбанкинд ирүүлнэ:
  - 8.1.1. Карт гаргах үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл хүссэн өргөдлийг 4 дүгээр хавсралтад заасан маягтын дагуу;
  - 8.1.2. Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн картын байгууллагын гишүүнээр элссэн тохиолдолд тухайн байгууллагаас авсан зөвшөөрөл болон түүнтэй байгуулсан гэрээ;
  - 8.1.3. Карт гаргах болон гүйлгээний боловсруулалт хийх системийн дэлгэрэнгүй мэдээлэл, техникийн баримт бичиг, системийг нийлүүлсэн компанитай байгуулсан гэрээ;
  - 8.1.4. Карт гаргах, бүртгэх, нийтэд тараах зэрэг картын үйл ажиллагаанд мөрдөх бодлогын болон эрх зүйн баримт бичиг (дүрэм, гэрээ гэх мэт);
  - 8.1.5. Дараахь үйл ажиллагааг зохицуулсан журмын баталгаажуулсан хуулбар:
    - а) Маргаан шийдвэрлэх;

- б) Карт хэвлэх, олгох;
  - в) Нууцлал, аюулгүй байдлыг хангах;
  - г) Төлбөр тооцоог гүйцэтгэх;
  - д) Төлбөрийн картын системийн тасралтгүй, найдвартай үйл ажиллагааг хангах;
  - е) Мэдээллийн технологийн үндсэн болон нөөц төвийн;
  - ё) Эрсдэлийн удирдлагын;
  - ж) Бусад.
- 8.1.6. Картын үйл ажиллагааг хариуцах нэгжийг тодорхойлсон зураглал, ажлын байрны дэлгэрэнгүй тодорхойлолт;
- 8.1.7. Монголбанкнаас баталсан “Үйлчилгээний хураамж, шимтгэлийн ерөнхий нөхцөл”-д заасны дагуу “зөвшөөрлийн материал хүлээж авах” хураамжийг төлсөн баримт;
- 8.1.8. Карт гаргагч нь шууд бус оролцогч бол төлбөр тооцооны төлөөлөгчийн зөвшөөрөл;
- 8.1.9. Карт гаргах үйл ажиллагаа эрхлэхэд үүсэж болзошгүй эрсдэлийг даах баталгаа;
- 8.1.10. Монголбанкнаас шаардлагатай гэж үзсэн бусад.
- 8.2. Карт гаргах үйл ажиллагааны зөвшөөрөл авах хүсэлт гаргагч нь энэ журмын 8.1-д заасан баримт бичгийг ирүүлэхдээ Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн 12.1, энэ журмын 4 дүгээр бүлэгт заасан шаардлагыг хэрхэн хангасан тухай тайлбарыг хавсаргана.
- 8.3. Карт хүлээн авах үйл ажиллагааны зөвшөөрөл авах хүсэлт гаргагч нь Үндэсний төлбөрийн системийн 11.1-д болон дор дурдсан баримт бичгийн эх хувийг эсхүл баталгаажуулсан хувийг бүрдүүлж Монголбанкинд ирүүлнэ:
- 8.3.1. Карт хүлээн авах үйл ажиллагааны зөвшөөрөл хүссэн өргөдлийг 4 дүгээр хавсралтад заасан маягтын дагуу;
- 8.3.2. Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн картын байгууллагын гишүүнээр элссэн тохиолдолд тухайн байгууллагаас авсан зөвшөөрөл болон түүнтэй байгуулсан гэрээ;
- 8.3.3. Карт хүлээн авах болон гүйлгээний боловсруулалт хийх системийн дэлгэрэнгүй мэдээлэл, техникийн баримт бичиг, системийг нийлүүлсэн компанитай байгуулсан гэрээ;
- 8.3.4. Карт хүлээн авах үйл ажиллагаанд мөрдөх бодлогын болон эрх зүйн баримт бичиг (дүрэм, гэрээ гэх мэт);
- 8.3.5. Дараахь үйл ажиллагааг зохицуулсан журмын баталгаажуулсан хуулбар:
- а) Маргаан шийдвэрлэх;
  - б) Нууцлал, аюулгүй байдлыг хангах;
  - в) Төлбөр тооцоог гүйцэтгэх;
  - г) Төлбөрийн картын системийн тасралтгүй, найдвартай үйл ажиллагааг хангах;
  - д) Мэдээллийн технологийн үндсэн болон нөөц төвийн;
  - е) Эрсдэлийн удирдлагын;
  - ё) Бусад.
- 8.3.6. Карт хүлээн авах техник тоног төхөөрөмжийн дэлгэрэнгүй тайлбар, техникийн баримт бичиг, нууцлал, аюулгүй байдлыг хангасан тухай;

- 8.3.7. Картын үйл ажиллагааг хариуцах нэгжийг тодорхойлсон зураглал, ажлын байрны дэлгэрэнгүй тодорхойлолт;
- 8.3.8. Монголбанкнаас баталсан “Үйлчилгээний хураамж, шимтгэлийн ерөнхий нөхцөл”-д заасны дагуу “зөвшөөрлийн материал хүлээж авах” хураамжийг төлсөн баримт;
- 8.3.9. Карт хүлээн авах үйл ажиллагаа эрхлэхэд үүсэж болзошгүй эрсдэлийг даах баталгаа;
- 8.3.10. Монголбанк шаардлагатай гэж үзсэн бусад.
- 8.4. Карт хүлээн авах үйл ажиллагааны зөвшөөрөл авах хүсэлт гаргагч нь энэ журмын 8.3-т заасан баримт бичгийг ирүүлэхдээ Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн 12.1, энэ журмын 5 дугаар бүлэгт заасан шаардлагыг хэрхэн хангасан тухай тайлбарыг хавсаргана.
- 8.5. Процессорын үйл ажиллагааны зөвшөөрөл авах хүсэлт гаргагч нь Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн 11.1-д болон дор дурдсан баримт бичгийн эх хувийг эсхүл баталгаажуулсан хувийг бүрдүүлж Монголбанкинд ирүүлнэ:
- 8.5.1. Процессорын үйл ажиллагааны зөвшөөрөл хүссэн өргөдлийг 5 дугаар хавсралтад заасан маягтын дагуу;
- 8.5.2. Хамтран ажиллах карт гаргагч, хүлээн авагчтай байгуулсан гэрээ;
- 8.5.3. Карт гаргах болон гүйлгээний боловсруулалт хийх системийн дэлгэрэнгүй мэдээлэл, техникийн баримт бичиг, системийг нийлүүлсэн компанитай байгуулсан гэрээ;
- 8.5.4. Процессорын үйл ажиллагаанд мөрдөх бодлогын болон эрх зүйн баримт бичиг (дүрэм, гэрээ гэх мэт);
- 8.5.5. Дараахь үйл ажиллагааг зохицуулсан журмын баталгаажуулсан хуулбар:
- а) Маргаан шийдвэрлэх;
  - б) Нууцлал, аюулгүй байдлыг хангах;
  - в) Төлбөр тооцоог гүйцэтгэх;
  - г) Төлбөрийн картын системийн тасралтгүй, найдвартай үйл ажиллагааг хангах;
  - д) Мэдээллийн технологийн үндсэн болон нөөц төвийн;
  - е) Эрсдэлийн удирдлагын;
  - ё) Бусад.
- 8.5.6. Монголбанкнаас баталсан “Үйлчилгээний хураамж, шимтгэлийн ерөнхий нөхцөл”-д заасны дагуу “зөвшөөрлийн материал хүлээж авах” хураамжийг төлсөн баримт;
- 8.5.7. Монголбанкнаас шаардлагатай гэж үзсэн бусад.
- 8.6. Процессорын үйл ажиллагааны зөвшөөрөл авах хүсэлт гаргагч нь энэ журмын 8.5-д заасан баримт бичгийг ирүүлэхдээ Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн 12.3, энэ журмын 6 дугаар бүлэгт заасан шаардлагыг хангасан тухай тайлбарыг хавсаргана.
- 8.7. Монголбанк энэ журмын 8.1, 8.3 болон 8.5-д заасан баримт бичгийг хянаж, бүрдүүлбэр дутуу, энэ журмын 4, 5, 6-р бүлэгт заасан шаардлагыг хангаагүй, нэмэлт баримт бичиг шаардлагатай тохиолдолд 60 (жар) хоногийн дотор хүсэлт гаргагчид албан бичгээр мэдэгдэнэ.
- 8.8. Хүсэлт гаргагч нь зөвшөөрлийн баримт бичгийн бүрдүүлбэрийг хангах, нэмэлт материал ирүүлэх тохиолдолд Монголбанкнаас баталсан “Үйлчилгээний хураамж, шимтгэлийн ерөнхий нөхцөл”-д заасан “зөвшөөрлийн материал хүлээж авах” хураамжийг дахин төлөхгүй.

- 8.9. Зөвшөөрөл олгох асуудлыг Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн 15 дугаар зүйлд заасны дагуу шийдвэрлэнэ.
- 8.10. Зөвшөөрөл олгох шийдвэр гарсан тохиолдолд хүсэлт гаргагч нь Монголбанкнаас баталсан “Үйлчилгээний хураамж, шимтгэлийн ерөнхий нөхцөл”-д заасан холбогдох зөвшөөрлийн хураамжийг төлнө.
- 8.11. Карт гаргах, хүлээн авах үйл ажиллаганы зөвшөөрөл авсан хүсэлт гаргагч нь картын нэр, төрөл нэмэх тохиолдолд энэ журмын 8.10-т заасан хураамжийг дахин төлөхгүй.
- 8.12. Зөвшөөрөл авах хүсэлт гаргагчийн ирүүлсэн материал нь Үндэсний төлбөрийн системийн тухай хуульд зааж, энэ журамд тодорхойлсон шаардлагыг хангасан, зөвшөөрөл олгохоос татгалзах үндэслэл байхгүй бол зөвшөөрлийг Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар олгоно.
- 8.13. Карт гаргах, карт хүлээн авах болон процессорын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг эхний удаа 4 (дөрвөн) жилийн хугацаатай олгоно.
- 8.14. Карт гаргагч, карт хүлээн авагч болон процессор нь зөвшөөрлийн хугацааг сунгах тухай хүсэлтийг энэ журмын 8.13-т заасан зөвшөөрлийн хугацаа дуусгавар болохоос 180 хоногийн өмнө гаргана.
- 8.15. Зөвшөөрөл сунгах хүсэлтийг энэ журмын 8.1-8.12-т заасны дагуу шийдвэрлэж, зөвшөөрлийг хугацаагүй олгоно.
- 8.16. Зөвшөөрөл эзэмшигч нь зөвшөөрөл авахад бүрдүүлсэн картын үйл ажиллагааны журам, заавар, бичиг баримт, гэрээ, техник технологи, програм хангамжид системд нөлөөлөхүйц өөрчлөлт оруулах тохиолдолд өөрчлөлтийн тухай мэдээллийг тухай бүр Монголбанкинд ирүүлнэ.
- 8.17. Монголбанк нь дараахь үндэслэлээр зөвшөөрөл олгох, сунгахаас татгалзана. Үүнд:
- 8.17.1. Зөвшөөрөл авах хүсэлтийн материал нь холбогдох хууль, тогтоомж, түүнд нийцүүлэн гаргасан эрх зүйн акт болон энэ журмын 4, 5, 6-р бүлэгт заасан шаардлагыг хангахгүй нь тогтоогдсон;
- 8.17.2. Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн 15.3-т заасан хугацаа хэтэрсэн;
- 8.17.3. Үндэсний төлбөрийн систем, эдийн засгийн аюулгүй байдал, санхүүгийн тогтвортой байдалд сөрөг нөлөөтэй гэж Монголбанк үзсэн.
- 8.18. Зөвшөөрөл олгох, сунгахаас татгалзсан тухай Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн 15.2-т заасны дагуу хүсэлт гаргагчид албан бичгээр мэдэгдэнэ.
- 8.19. Зөвшөөрөл олгох, сунгахаас татгалзсан хариу авсан хүсэлт гаргагч дахин хүсэлт гаргах тохиолдолд энэ журмын 8.1-8.12-т заасны дагуу холбогдох баримт бичгийг шинээр бүрдүүлнэ.
- 8.20. Монголбанк нь Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн 19.1.2-т заасан буюу дараахь үндэслэлээр карт гаргах, карт хүлээн авах болон процессорын үйл ажиллагааны зөвшөөрлийг түдгэлзүүлнэ:
- 8.20.1. Карт эзэмшигч, КУБ-ын төлбөр, тооцоог гүйцэтгээгүй, удаа дараа саатуулсан, буруу гүйцэтгэсэн нь тогтоогдсон;
- 8.20.2. Үйл ажиллагааны техникийн нууцлал, аюулгүй байдал, тасралтгүй, найдвартай ажиллагааг зохих түвшинд хангаагүй нь тогтоогдсон;



- 8.20.3. Монголбанк, клирингийн төвөөс тавьсан шаардлагыг удаа дараа зөрчсөн эсхүл биелүүлэхээс татгалзсан нь баримтаар нотлогдсон;
- 8.20.4. Сүлжээний дүрэм, хамтран ажиллах гэрээг мөрдөж ажиллах тухай бусад оролцогчдын шаардлагыг удаа дараа хүлээж аваагүй эсхүл биелүүлэхээс татгалзсан нь баримтаар нотлогдсон;
- 8.20.5. Хууль тогтоомжид заасан бусад үндэслэлээр.
- 8.21. Төлбөрийн системийн хяналт, шалгалтаар энэ журмын 8.20-д заасан зөрчлийг арилгасан нь тогтоогдвол шалгалтын дүгнэлтийг үндэслэн Монголбанкны шийдвэрээр холбогдох зөвшөөрлийг сэргээнэ.
- 8.22. Карт гаргах, карт хүлээн авах болон процессорын үйл ажиллагааны зөвшөөрлийг сэргээхдээ түдгэлзүүлсэн хугацааг нөхөн олгохгүй.
- 8.23. Монголбанк нь Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн 19.2-т заасан үндэслэлээр карт гаргах, карт хүлээн авах болон процессорын үйл ажиллагааны зөвшөөрлийг хүчингүй болгоно.
- 8.24. Энэ журмын 8.23-т заасны дагуу Монголбанк тухайн үйл ажиллагааны зөвшөөрлийг хүчингүй болгох тухай шийдвэр гарсан өдрөөс хойш 6 (зургаан) сарын хугацаанд дахин уг этгээдээс тухайн үйл ажиллагааг эрхлэх зөвшөөрөл хүссэн хүсэлтийг хүлээн авахгүй.
- 8.25. Хүсэлт гаргагч нь энэ журмын 8.24-т заасан хугацаа өнгөрсний дараа энэ журамд заасан шаардлагын дагуу холбогдох баримт бичгийг шинээр бүрдүүлэн хүсэлт гаргаж болно.
- 8.24. Энэ журмын 8.20 болон 8.23-т заасан үндэслэлээр карт гаргах, карт хүлээн авах болон процессорын үйл ажиллагааны зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох арга хэмжээ авахтай холбогдон гарсан зардлыг тухайн хуулийн этгээд хариуцна.

## **ЕС. КАРТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НӨХЦӨЛ, ХҮҮ, ШИМТГЭЛ**

- 9.1. Карт гаргагч дараахь шимтгэлийг авч болно:
- 9.1.1. Карт хэвлэсний шимтгэл;
- 9.1.2. Карт идэвхжүүлэх буюу тэдгээрт өөрчлөлт оруулах шимтгэл;
- 9.1.3. Үйлчилгээний шимтгэл;
- 9.1.4. Холбогдох бусад.
- 9.2. Карт хүлээн авагч дараахь шимтгэлийг авч болно:
- 9.2.1. КУБ-ын шимтгэл (Төрийн үйлчилгээний төлбөрөөс бусад);
- 9.2.2. АТМ-аас бэлэн мөнгө авах;
- 9.2.3. ПОБ-оос бэлэн мөнгө авах;
- 9.2.4. ПОС төхөөрөмжийн тусламжтайгаар бэлэн мөнгө авах гүйлгээний шимтгэл (cashback);
- 9.2.5. Төрийн үйлчилгээний төлбөр хүлээн авсны шимтгэл;
- 9.2.6. Бусад.
- 9.3. Клирингийн төв дараахь шимтгэлийг авч болно:
- 9.3.1. Гишүүнчлэлийн хөлс;
- 9.3.2. Карт гаргагч, карт хүлээн авагчийн гүйлгээний шимтгэл;

### 9.3.3. Бусад.

- 9.4. Энэ журмын 9.2.1-д заасан шимтгэлийн дээд хязгаар нь 3 хувь, доод хязгаар нь 1 хувь байна.
- 9.5. Энэ журмын 9.2.1, 9.3.1-д заасан шимтгэлийг карт эзэмшигч төлөхгүй.
- 9.6. Энэ журмын 9.2.2-т заасан шимтгэл нь 500 (таван зуун) төгрөгөөс дээшгүй байх ба шимтгэлийг карт эзэмшигч төлнө.
- 9.7. Энэ журмын 9.2.3, 9.2.4-т заасан шимтгэл нь 1,000,000 (нэг сая) төгрөг хүртэлх гүйлгээнд 500 (таван зуун) төгрөгөөс дээшгүй байх ба шимтгэлийг карт эзэмшигч төлнө.
- 9.8. Энэ журмын 9.2.5-д заасан шимтгэл нь 300 (гурван зуун) төгрөгөөс дээшгүй байх ба шимтгэлийг карт эзэмшигч төлнө.
- 9.9. Оролцогч нь шимтгэлийг дараахь байдлаар хуваана:
  - 9.9.1. Карт хүлээн авагч нь КҮБ-д хийгдсэн гүйлгээний дүнгийн 0.3 хувиас доошгүй хэмжээтэй шимтгэлийг карт гаргагчид төлнө (Төрийн үйлчилгээний төлбөрөөс бусад);
  - 9.9.2. Энэ журмын 9.2.5-д заасан шимтгэлийн 30 хувиас доошгүй хэмжээтэй шимтгэлийг карт гаргагчид төлнө.

## **АРАВ. КАРТЫН ГҮЙЛГЭЭНД БАРИМТЛАХ СУУРЬ ЗАРЧИМ**

- 10.1. Карт гаргагч, карт хүлээн авагч хоорондын картын гүйлгээг ҮЦГТ болон клирингийн төвөөр дамжуулан, бодит цагийн горимд, олон улсын санхүүгийн мэдээний ISO8583 стандартын дагуу гүйцэтгэнэ.
- 10.2. Карт хүлээн авагч нь карт гаргагчаас гүйлгээний зөвшөөрөл өгсний дараа гүйлгээг хийнэ. Зөвшөөрөлгүй хийсэн картын гүйлгээнээс гарах аливаа эрсдэлийг карт хүлээн авагч хариуцна.
- 10.3. Клирингийн төв нь тухайн өдрийн үр дүнгийн тооцооллыг өдөрт нэг буюу түүнээс дээш удаа харилцан суутгах зарчмаар, төгрөгөөр илэрхийлж, үр дүнгийн тооцооллын хаалтын дүнг тухайн оролцогчийн эсвэл түүний төлбөр тооцооны төлөөлөгчийн Монголбанкн дахь харилцах дансанд тусгана.
- 10.4. Картын төлбөр, тооцоонд Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар тогтоосон их, бага дүнтэй гүйлгээний хязгаар хамаарахгүй бөгөөд гүйлгээний дүнгээс үл хамааран энэ журмаар зохицуулна.
- 10.5. Оролцогч нь энэ журмын 10.3-т заасан үр дүнгийн төлбөр тооцоог дараагийн ажлын өдрийн 17.10 цагт багтаан гүйцэтгэж чадаагүй тохиолдолд клирингийн төв нь тухайн оролцогчийн төлбөрийн картын систем ашиглах эрхийг түдгэлзүүлнэ.

*[/Энэ заалтыг Монголбанкны Ерөнхийлөгчийн 2020 оны 02 дугаар сарын 19-ны өдрийн А-41 дүгээр тушаалаар нэмсэн/](#)*

- 10.6. Эрхийг нь түдгэлзүүлсэн оролцогч энэ журмын 10.5-д заасан үр дүнгийн төлбөр тооцоог бүрэн барагдуулсан тохиолдолд төлбөрийн картын систем ашиглах эрхийг сэргээнэ.

*[/Энэ заалтыг Монголбанкны Ерөнхийлөгчийн 2020 оны 02 дугаар сарын 19-ны өдрийн А-41 дүгээр тушаалаар нэмсэн/](#)*

## **АРВАН НЭГ. КАРТЫН ТӨЛБӨР, ҮР ДҮНГИЙН ТООЦООЛОЛ**

- 11.1. Оролцогч нь картын гүйлгээг зөвхөн төгрөгөөр илэрхийлж, гүйлгээ дамжуулах өдрийн турш илгээж, дамжуулж, хүлээн авна.
- 11.2. Карт хүлээн авагчтай гэрээ байгуулсан, Монгол Улсад бүртгэлтэй КҮБ нь картын төлбөр, тооцоог зөвхөн төгрөгөөр гүйцэтгэнэ.

- 11.3. Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн 5.1.30-д заасан карт гаргагч, карт хүлээн авагчийн үр дүнгийн тооцооллын хаалтын дүнг тухайн оролцогчийн эсвэл түүний төлбөр тооцооны төлөөлөгчийн Монголбанкин дахь харилцах дансаар, Банксүлжээ системд, төгрөгөөр гүйцэтгэнэ.
- 11.4. Карт хүлээн авагч нь залруулгын гүйлгээтэй холбоотой баримтын бүрдлийг хариуцна.
- 11.5. Залруулгын гүйлгээг буруу гүйцэтгэснээс үүсэх эрсдэлийг карт хүлээн авагч бүрэн хариуцна.
- 11.6. ҮЦГТ болон клирингийн төв нь карт хүлээн авагчаас ирүүлсэн залруулгын хүсэлтийг үндэслэн гүйлгээний мэдээллийг хянаж, зөвшөөрөл олгоно. Тухайн гүйлгээ нь зөвшөөрөл олгосон өдрийн үр дүнгийн тооцоололд орно.
- 11.7. Шаардлагатай гэж үзсэн тохиолдолд Монголбанкны Ерөнхийлөгчийн шийдвэрээр оролцогчид урьдчилан мэдэгдсэний үндсэн дээр үр дүнгийн тооцооллын хаалтын дүнгээр тухайн өдрийн гүйлгээг хязгаарлаж болно.

### **АРВАН ХОЁР. ҮНДЭСНИЙ ТӨЛБӨРИЙН КАРТ**

- 12.1. Үндэсний төлбөрийн картын оноосон нэр нь “₮ карт” буюу “Төгрөг карт” байна. Олон улсад ашиглах нэр нь “₮ card” байна.
- 12.2. Энэ журмын 6 дугаар хавсралтад заасны дагуу ₮ картын загвар буюу картын хэмжээ, нүүрэн тал болон ар талд байх мэдээллийг байршуулна.
- 12.3. Монголбанк нь карт гаргагч бүрд БИН дугаар олгож, ашиглалтад хяналт тавина. БИН дугаарыг MNS ISO/IEC 7812-1, MNS ISO/IEC 7812-2 болон ISO3166 стандартын дагуу 7 дугаар хавсралтад зааснаар олгоно.
- 12.4. ₮ картын лого, түүний байршлыг 8 дугаар хавсралтад зааснаар байрлуулна.
- 12.5. ₮ картын холограмын загвар, түүний байршлыг 9 дүгээр хавсралтад зааснаар байрлуулна.
- 12.6. ₮ картан дээр байрших ҮЦГТ-ийн лого, түүний байршлыг 10 дугаар хавсралтад зааснаар байрлуулна.
- 12.7. Карт гаргагч, карт хүлээн авагч нь ₮ карт болон түүнтэй холбоотой гарын авлага, сурталчилгаанд 8 дугаар хавсралтын 1.1, 1.2 болон 10 дугаар хавсралтын 1.1, 1.2-т заасны дагуу ₮ картын лого, ҮЦГТ-ийн логог ашиглана.
- 12.8. Карт гаргагч нь ₮ картын биет загварыг Монголбанкинд ирүүлж баталгаажуулна.
- 12.9. Монголбанк нь ₮ картын үйл ажиллагаанд мөрдөх шаардлага, үйл ажиллагааны заавар, журмыг батална.
- 12.10. Карт гаргагч нь Монголбанкны зөвшөөрөлтэйгөөр олон улсын картын үйл ажиллагаа эрхлэгч байгууллагатай хамтран “Хосолсон ₮ карт” гаргаж болно.
  - 12.10.1. “Хосолсон ₮ карт”-д олон улсын картын үйл ажиллагаа эрхлэгч байгууллагаас олгосон БИН дугаар ашиглаж болно.
  - 12.10.2. Монголбанк нь “Хосолсон ₮ карт”-аар хийсэн гүйлгээнээс үйлчилгээний шимтгэл авч болно.

### **АРВАНГУРАВ. КАРТЫН СИСТЕМИЙН ТАСРАЛТГҮЙ, НАЙДВАРТАЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА**

- 13.1. Оролцогч нь дараахь шаардлагыг хангаж ажиллана:

- 13.1.1. Монголбанкнаас баталсан холбогдох журмын дагуу картын системийн тасралтгүй, найдвартай үйл ажиллагааг хангаж ажиллана.
  - 13.1.2. Системийн тасралтгүй ажиллагаа, системийн аюулгүй байдлын талаар баримтлах бодлого, техникийн стандартыг боловсруулсан байна.
  - 13.1.3. Өөрийн сүлжээний тасралтгүй, найдвартай ажиллагаанд тавигдах шаардлагыг тодорхойлж, түүнтэй холбоотой үүссэн системийн саатлыг шийдвэрлэнэ.
  - 13.1.4. Нөөц сүлжээ, түүний найдвартай ажиллагаа, тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг жилд нэг удаа туршин баталгаажуулна.
